



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 03 сарын 27 өдөр

Дугаар А/189

Булган сум

Хичээлийн хэрэглэгдэхүүний зардалд хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам” тушаалын 2.1.4 дэх заалт, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ес дэх удаагийн сонгуулийн IV хуралдаанаар батлагдсан аймгийн Засаг даргын “Булганы сэргэлт” үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.2.1 (Боловсрол) дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сэлэнгэ сумын Ерөнхий боловсролын сургуулийн Хөгжмийн кабинетын засвар, дизайн технологийн хичээлийн хэрэглэгдэхүүнд шаардагдах зардалд 7,000,000 (долоон сая) төгрөгийг зарцуулсугай.

2. Шаардагдах хөрөнгийг хавсралтаар баталж, аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс санхүүжүүлэхийг Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Наранбаяр)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР



Аймгийн Засаг даргын 2025. оны
03 дугаар сарын 27-ны/ний өдрийн А/180 дүгээр
захирамжийн хавсралт

ШААРДАГДАХ ХӨРӨНГИЙН ТӨСӨВ

д/д	Хэрэгцээ шаардлага	Шаардагдах төсөв
1	2	3
1	Хөгжмийн кабинетын засвар тохижилт (Акустик хавтан)	5.000.000
2	Дизайн технологийн хичээлийн хэрэглэгдэхүүн	2.000.000
	НИЙТ	7.000.000